

**“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТ**

2023.12.15

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Биелэлт	Биелэлт хувь
1	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын салбарын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх;	- Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг тухай бүр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар болон аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн байран дахь мэдээллийн самбар, албан ёсны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийгмийн даатгалын салбарын албан хаагчид болон иргэд, даатгуулагчдад сурталчлан ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> • Сурталчилгааны самбар – 32 • Албан ёсны цахим хуудас – 32 • Хэвлэл мэдээллийн хэрэгсэл- 5 • Албан хаагчийг уриалан хувийн цахим хаяг-85 Эдгээр эх сурвалжаар давхардсан тоогоор 88,973 хүнд мэдээлэл хүрсэн болно.	
	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Тайлант хугацаанд “Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээ”-г Нийгмийн даатгалын байгууллагын салбарын онцлогт тохируулан Авлигаас ангид байж, албан үүргээ гүйцэтгэсний төлөө ажил олгогч, даатгуулагч иргэдэд давуу тал олгох, тэднээс шан харамж авах зэрэг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, шаардсан тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгддэг байх талаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд тухайн аймгийн томоохон худалдааны төвүүдээр дамжуулан “Даатгуулагчийн өдөрлөг”, Албан хаагч нарт зориулсан сургалт, АХА тэмцээн, тус тус зохион байгуулж Авлигын эсрэг нөлөөлөл үзүүлэн ажиллав. Дээрх арга хэмжээг зохион байгуулсан хэлбэрээр задалбал	

			<ul style="list-style-type: none"> • Иргэд даатгуулагчдад чиглэсэн өдөрлөг-3 • Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Дэвжээ-2023” тэмцээнийг санаачлан зохион байгуулж 12 баг оролцож Реформ баг түрүүлсэн. • Нийгмийн даатгалын ажилтанд чиглэсэн өдөрлөг-3 • “Нийгмийн даатгал- Авлигагүй бүс” цахим аян- 3 • Төрийн албан хаагчдад авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын хор хөнөөлийг сурталчлан таниулах, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, хүсэл зоригоо илэрхийлэх зорилгоор сумын ИТХ, ЗДТГ, ЕБС-тай хамтран зохион байгуулсан ба 288 хүн оролцсон. • “Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс ангид төрийн албан хаагч” сэдэвтэй эсээ бичлэгийн уралдаан-1 • АХА тэмцээн-2 • Тв шторк-4 • Теле зохиомж-2 • Зурагт хуудас-4 • Нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо-78,605 байна. 	
1.3	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Тайлант хугацаанд “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэн ажиллуулж байгаа бөгөөд уг самбар нийт нийгмийн даатгалын 33 байгууллагад ажиллуулж байна. Тайлант хугацаанд нийт 97 мэдээлэл байршуулсан .	
1.4	Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий цахим гарын авлага бэлтгэж, салбарын албан хаагчид болон олон нийтэд хүргэсэн байх;	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ мөн	•Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Дэвжээ-2023” тэмцээнийг санаачлан зохион байгуулж 12 баг оролцож Реформ баг түрүүлсэн. •Нийгмийн даатгалын ажилтанд чиглэсэн өдөрлөг-3 •“Нийгмийн даатгал- Авлигагүй бүс” цахим аян- 3 •Төрийн албан хаагчдад авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын хор хөнөөлийг сурталчлан	

		<p>лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр салбарын албан хаагчид болон олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.</p>	<p>таниулах, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх, олон нийтийн дуу хоолойг сонсох, хүсэл зоригоо илэрхийлэх зорилгоор сумын ИТХ, ЗДТГ, ЕБС-тай хамтран зохион байгуулсан ба дээрх арга хэмжээд оролцон хүн бүрт Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын байгууллагын бэлтгэсэн нийт 300 ширхэг тараах материал хүргэсэн.</p> <p>-Мөн Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт; “Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалт; Төрийн албаны зөвлөлийн вебинар сургалт; Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл сургалтын сургагч багш нарын сургалтдараах сургалтад “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр хөтөлбөрт оруулж, албан хаагчидад тус тус хүргэсэн.</p>	
2	АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
	<p>2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;</p>	<p>-Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>-Нийгмийн даатгалын салбарын шинэ томилогдсон болон нийт албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг шинээр томилогдсон нийт 119 хаагчид танилцуулан сургалт зохион байгуулсан.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр ойрын хугацаанд хийх ажлын хүрээнд цахим сургалтын https://surgalt.ndaatgal.mn/ системд “Авлигагүй, ёс зүйтэй хамт олон” хавтас үүсгэж, холбогдох сургалтын материал, видео ба танилцуулага хичээлүүдийг нэгтгэж оруулан албан хаагчдаар судлуулсан.</p>	
	<p>2.2. НДЕГ-ын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга</p>	<p>-Нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн газраас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж төрийн мэдээллийг нээлттэй, ил тод болгох, цахимжилтыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1132 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсыг шинэчлэх талаар зөвлөмж хүргүүлснээр Нийтийн мэдээллийн ил тод</p>	

	хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;		<p>байдлын тухай хуульд заасан 260 мэдээллийг цахим хуудсанд байршуулаж нээлттэй, ил тод болгосон, мэдээллийн самбар болон 44 төрлийн мэдээллийг шинэчилж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан болно.</p> <p>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, албан хаагчдыг чадавхижуулах, ажил олгогчдод мэдээлэл өгөх сургалтын удирдамж”-ын дагуу Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртлыг бууруулах, төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах чиглэлээр сургагч багш бэлдэж 2023 оны 09 дүгээр сарын 13-наас 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр дуустал хугацаанд 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 1195 ажилтан, албан хаагчид, 4740 ажил олгогч байгууллагын 6726 даатгуулагчдад сургалтыг явуулсан байна.</p>	
3	2.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссуудын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах;	<p>- ЭХМКомиссын гишүүдийг хамруулсан байх</p> <p>- Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссуудын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “ёс зүйн” болон “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр хийсэн онлайн сургалтад эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 17 гишүүн, өрх сумын 26 эмч нар хамрагдаж нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахаар ирсэн иргэд, даатгуулагчаас шан харамж авах, шаардахгүй байх болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтуудын талаар тус тус эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн үр дүн бүхий сургалтыг зохион байгуулсан.</p>	
	3 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ БИИ БОЛГОХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
	3.1 НДЕГ болон хувийн хэвшлийн байгууллагын	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид	Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс аж ахуйн нэгж,	

<p>хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;</p>	<p>байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулсан байх; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>байгууллага, албан тушаалтан, иргэдтэй Хамтран ажиллах, Худалдах худалдан авах, Хөлсөөр ажиллах, Түрээсийн гэрээ, Хөдөлмөрийн гэрээг тус тус байгуулсан. Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг хөндөн “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх”, “уг заалтыг зөрчсөн тохиолдолд талууд хариуцлага хүлээх”, “эрх бүхий байгууллагад мэдээлэхийг үүрэг болгосон” заалтуудыг тус тус нэмж тусгасан. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын байгууллага нийт 343 гэрээнд тусган байгуулсан ба уг заалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гараагүй байна.</p>	
<p>3.2 “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах;</p>	<p>-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх</p>	<p>-Тайлант хугацаанд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс тус бүрийн харьяа ажил олгогчийн нягтлан бодогч нарт Авлигын эсрэг хууль, Нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд, тус хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтууд болон нэмэгдсэн болон нэршил өөрчлөгдсөн даатгуулагчийн төрлийн кодын талаарх мэдээллийг өгч ажиллав. -Мөн олон нийтийн цахим хэрэгсэл болон нийгмийн даатгалын хэлтэст тайлан өгдөг аж ахуйн нэгж, байгууллагын цахим группт нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулж салбар дундын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөрдүүлж ажиллах, хуулийг сурталчлан таниулах арга хэмжээг байнга авч ажиллаж байна.</p>	
<p>3.3. НДЕГ-ын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах;</p>	<p>- Байгууллагын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсан байх</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын www.ndaatgal.mn болон www.shilen.gov.mn 2023 онд шинэчлэн чиг үүрэгт хамаарах мэдээллийг ил тод, нээлттэй, шилэн хэлбэрээр олон нийтэд хүргэж байна. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 68 төрлийн чиг үүрэгт хамаарах мэдээллийг www.ndaatgal.mn цахим хуудсанд байршуулснаар шилэн индексийн үнэлгээ 90.90 хувьд хүрсэн болно. 	

			<ul style="list-style-type: none"> “Шил ажиллагаа”-ны хүрээнд нийгмийн даатгалын сан тус бүрийн 2008-2022 оны (1) орлого, зарлагын гүйцэтгэл болон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авсан хүний тоо, (2) нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө, (3) Засгийн газрын бонд гэсэн 3 төрлийн 5144 мэдээллийг цахим хуудсанд байршуулснаар Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл олон нийтэд ил тод боллоо. 	
4	АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
	<p>4.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлыг зохион байгуулах;</p>	<p>-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх</p>	<p>-Засгийн газраас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж төрийн мэдээллийг нээлттэй ил тод болгох, цахимжилтыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах зорилгоор “Шил ажиллагаа”-г эхлүүлж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг ил тод байршуулсан байдалд үнэлгээ хийж олон нийтэд мэдээлэл нийтлэх ажлыг зохион байгуулсан. Салбарын хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээг мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр дараах мэдээллийг дүгнэсэн. Үүнд: -Нэг чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт 9; -Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал 6; -Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа 17; -Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл 1; -Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал 2; -Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 91.4 хувиар “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж, үнэлгээний дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/831 дүгээр албан бичгээр болон цахимаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Мөн нийгмийн даатгалын салбарын нээлттэй мэдээллийг ил тод болгох, шилэн индексийн үнэлгээг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны</p>	

			<p>“Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 01/1132, мөн Дотоод аудит, мониторингийн газрын 2023 оны “Судалгаа ирүүлэх тухай” 03/1180 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Мөн “Ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, нийт байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, сургалтын файл хичээлүүдийг албан хаагчдад тараан өгч, бие даан судлуулан ажилласан.</p>	
4.2	<p>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгаж, авлигын эрсдэл ба авлига, хүнд суртал гарах боломжийг бууруулах;</p>	<p>-2-оос доошгүй үйлчилгээг шинээр цахимжуулсан байна; -1-ээс доошгүй цахим үйлчилгээг сайжруулсан байна;</p>	<p>-Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2023 оныг “НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЖИЛ” болгон зарласан. Энэхүү ажлын хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6-д “Нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох” зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээнээс 24 үйлчилгээг цахимжуулж, 10 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-д холбох ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэл, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд ажиллаж байна. Мөн 2020-2023 онуудад 24 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Үүнд: Сайн дурын даатгалын онлайн систем, Сайн дурын даатгуулагч эхийн шимтгэлийн тооцооны веб систем “Hybrid”, Нийгмийн даатгалын цахим дэвтэр, Тэтгэврийн цахим дэвтэр, Тушаалыг цахимаар илгээх, Зээлдэгч ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт бодит цагийн горимоор гаргах, Эмнэлгийн хуудас буюу хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Ажилгүйдлийн тэтгэмж, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж, QR код бүхий нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, Хөдөлмөрийн чадвар алдсаныг тогтоосон тухай актыг тус тус цахим хэлбэрт шилжүүлээд байна. Тэтгэврийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр,</p>	

			<p>оршуулгын тэтгэмжээс бусад тэтгэмжүүд цахимжсанаар иргэдийн хөрөнгө мөнгө, цаг завьг хэмнэж өөр төрлийн бусад ажлаа хийх зэрэг бодит үр дүнгүүд гарч байна. Нийгмийн даатгалын үйлчилгээнүүд үнэ төлбөргүй, цахим хэлбэрт шилжсэнээр авлига авах эрсдэл буурч, хүнд суртал багассан эерэг өөрчлөлтүүд бий болж байна.</p>	
	<p>4.3 Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргах;</p>	<p>-2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд гарсан дүгнэлт, зөвлөмжийг салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх</p>	<p>-Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласан шийдвэр, нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн даатгалын хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцүүлэг сургалтыг салбарын хэмжээнд өнөөдөр /2023.03.31/ зохион байгууллаа. Сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, БНСУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, хяналт шалгалтын байцаагч нийт 200 гаруй албан хаагч танхим болон цахимаар хамрагдлаа. Сургалтыг НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын дарга Д.Ганзориг чиглүүлэн явуулж, “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд”, “Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчлийг шалгахад анхаарах асуудал”, “Шүүхэд нэхэмжлэл гаргах тухай” сэдвийн хүрээнд ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах шинжээч Ш.Мааяа, Т.Мөнгөнцэцэг, АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Баяртөгс, НПГ-ын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Н.Алтантүлхүүр, МӨХ-ны гишүүн өмгөөлөгч П.Амгаланбаатар нар оролцогчдод мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгч, оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа.</p> <p>-Авилгын эсрэг хууль, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс</p>	

			<p>урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 2022 оны төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын meduuleg.iaас.mn бүрдүүлэлтийн системд хуульд заасан хугацаанд гаргаж, тайлагнан баталгааны хуудсыг баталгаажуулж, эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд 1 удаа тайлагнасан.</p> <p>-Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртлыг бууруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн холбогдох аймаг, нийслэл, дүүргийн хэлтсүүдийн албан хаагчидтай холбогдон шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажиллав.</p> <p>-Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1132 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсыг шинэчлэх талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.</p>	
	<p>4.4 Үйлчлүүлэгчдээс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах;</p>	<p>- Сэтгэл ханамжийн судалгааг авсан байх; - Судалгааны дүгнэлтэд үндэслэн арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/1884 дугаар албан бичгийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 31-ний өдрийг дуустал зохион байгууллаа. Уг судалгаанд нийт 21 аймаг, 9 дүүрэг, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нийт 6741 иргэд, даатгуулагч, үйлчлүүлэгч цахимаар болон биечлэн хамрагдсан байна. Сэтгэл ханамжийн судалгааг нийгмийн даатгалын үйлчилгээний хурдан шуурхай, хялбар байдал, ажилтны харилцаа хандлага, үйл ажиллагааны ил тод байдал, авлига, ашиг сонирхол зэрэг агуулгыг хамарсан нийт 10 асуулттай боловсруулсан.</p> <p>Нийт ирүүлсэн судалгааны хуудаснаас 7 нэгжийн 621 мэдээллийг нэгтгэж дүгнэлээ. Судалгаанд хамрагдагчдын 59.1 хувь нь эмэгтэй, 40.9 хувь нь эрэгтэй байна. Насны бүлгийн хувьд 0.8 хувь нь 20 нас хүртэл, 14.1 хувь нь 20-29 насны, 29.7 хувь нь 30-39 насны, 20.9 хувь нь 40-49 насны, 24.9 хувь нь 50-59 насны, 9.8 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна. Сэтгэл ханамжийн судалгааг нийгмийн</p>	

			<p>даатгалын үйлчилгээний хурдан шуурхай, хялбар байдал, ажилтны харилцаа хандлага, үйл ажиллагааны ил тод байдал, авлига, ашиг сонирхол зэрэг агуулгыг хамарсан нийт 10 асуулттай боловсруулсан.</p> <p>Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын талаар 54.8 хувь нь мэдээлэл ил тод байдаг, 38.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Мөн нийгмийн даатгалын үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу гэсэн асуултад 96.3 хувь нь үгүй гэж хариулжээ.</p>	
5	БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД			
	<p>5.1 Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1 дүгээр улиралд батлан, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, биелэлт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр тайлагнаж, нийт албан хаагчдад танилцуулах;</p>	<ul style="list-style-type: none"> - Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; - Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх. 	<p>-Нийгмийн даатгалын ерөнхий газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хагас жилийн биелэлтийг hutulbur.iaас.mn сайтад 7 сарын 1-ний өдөр байршуулсан ба уг биелэлт нь 87%-тай үнэлэгдсэн.</p> <p>-Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтыг бүх нийгмийн даатгалын газар, хэлтэст 2023.09.07-2023.10.26-ний өдрийн хугацаанд зохион байгуулсан ба уг сургалтын нэг агуулга буюу “Авлига, ашиг сонирхлоос ангид байх” сэдэвт Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 оны хагас жилийн үнэлгээ болон Авлигатай тэмцэх газраас жил бүр зохион байгуулдаг “Шударга байдлын үнэлгээний 2021-2022 оны дүнг нийт нийгмийн даатгалын байцаагч, ажилтанд танилцуулсан.</p> <p>-Нийгмийн даатгалын салбарын удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнийг /2023.09.28/ өдөр зохион байгуулсан уг зөвлөгөөнд нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагын 46 удирдах ажилтан оролцож уг хуралд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэгийн илтгэлд Авлига, ашиг сонирхлоос ангид байх, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон хагас жилийн үнэлгээний талаар тус тус танилцуулсан.</p>	
	<p>5.2 Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх</p>	<p>Чиглэлийг мөрдөн ажилласан байна.</p>	<p>Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” ХЭГ/595 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Шүүр”</p>	

<p>газрын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, дүнг хугацаанд нь гаргаж хүргүүлэх;</p>		<p>ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын салбарын төрийн захиргааны албан хаагчдыг хамруулан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын удирдлагуудад Төрийн албаны хууль тогтоомж, төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг зөрчиж томилсон албан хаагчдын томилсон үндэслэл, шалтгааныг сайтар нягтлан судалгааг гарган ирүүлэх чиглэлийг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр 01/529 дугаар албан бичгээр хүргүүлсэн. • Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс судалгааг албан бичиг, тайлбарын хамт авч нэгтгэн, тус газрын Дотоод аудит мониторингийн газар хянан, Төрийн албаны зөвлөлийн холбогдох мэргэжилтнээс тайлбар зөвлөгөө авч ажиллав. • Энэ ажлын хүрээнд нийгмийн даатгалын салбарын төрийн захиргааны 1226 албан хаагчийн ял шийтгэлтэй эсэх талаар шалгуулахаар Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэст хандан албан бичиг хүргүүлээд байна. Дээрх ажлын дүнд манай байгууллагын зөрчилтэй 13 албан хаагчаас Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй 6 албан хаагч, Төрийн албаны салбар зөвлөлд тусгай шалгалтын захиалгаа хүргүүлсэн 6 албан хаагч, мэргэжил тохирохгүй 1 албан хаагч байснаас зөрчил бүхий 7 албан хаагчийг чөлөөлөх арга хэмээ авав. 	
<p>5.3 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байх;</p>	<p>-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын төсөл ирүүлсэнтэй танилцаад дараах саналыг хүргүүлсэн. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст “ТЗ-8”, “ТЗ-9” албан тушаалын зэрэглэлд ажиллаж байгаа нийгмийн даатгалын байцаагч нь улсын байцаагчийн эрх авснаар “ТЗ-7” зэрэглэлд шилжин хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус мэдүүлэх үүрэг бий болдог. Хэдийгээр тухайн ажилтны албан тушаалын зэрэглэл өөрчлөгдөж байгаа боловч албан тушаалын тодорхойлолт</p>	

			<p>болон өдөр тутам хийж гүйцэтгэх ажлын чиг үүрэг хэвээр үргэлжилдэг тул ТЗ-8, ТЗ-9 ангилалд мөн адил ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэг гаргадаг байх талаарх саналаа 2023 оны 11 дүгээр сарын 01/2121 дугаартай бичгээр хүргүүлсэн.</p>	
	<p>5.4 Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажлыг санаачлан хийх талаар салбар нэгжийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>-Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх; -Тайлагнасан байх.</p>	<p>Салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтсийн даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах заалт тусгав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд хяналт тавьж ажиллах; • Нийгмийн даатгалын байгууллагын албан тушаалтны сахилга хариуцлага, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, албан хаагчтай холбоотой ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан хөгжүүлэх. • Авлигын гэмт хэрэг, зөрчил гарах эрсдэл, шалтгаан нөхцөлийг үнэлэн тогтоох, холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулах. Тус тус заалт оруулсан ба уг заалтуудын хүрээнд дараах соён гэгээрүүлэх чиглэлээр ажлыг зохион байгуулсан. ✓ Монгол улсын ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 131 байцаагч, ажилтнуудтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалт тусгасан. ✓ Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран цахим сургалтыг зохион байгуулсан. ✓ Хэлтсийн “Шударга ёс, хөгжилд-110” самбарын мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байцаагч, ажилчид болон иргэд, даатгуулагчдыг мэдээллээр ханган ажиллаж байна. 	

<p>5.5 Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг оруулж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>-Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх</p>	<p>-Нийгмийн даатгалын салбарын нийт албан хаагчид, хэлтэс, тасгийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн, алдаагүй гаргаж хүргүүлэх заалтуудыг тус тус нэмж тусгасан. -Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 720 албан хаагч байснаас 100 хувь буюу 720 албан хаагчийн ХАСХОМ гаргах зохион байгуулсан.</p>	
<p>5.6.Нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр зурагт хуудас түгээх;</p>	<p>-Зурагт хуудас хэвлүүлж, түгээсэн байх</p>	<p>Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, даатгуулагчид Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн зурагт хуудас, цахим ном, гарын авлага болон өөрийн бэлтгэсэн зурагт хуудсыг нийгмийн даатгалын байгууллагын бүх газар, хэлтсийн цахим сайт болон үйл ажиллагаа явуулж буй байранд байршуулан тус тус түгээсэн. -Сайтаар дамжуулан 366 постер хүргэсэн ба нийт 12,560 хүнд хүрсэн. -Нийгмийн даатгалын салбарын онцлогт тохирсон зурагт хуудас хийж өдөрлөг, ажил олгогчийн зөвлөгөөний үеэр болон үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд хүргэсэн 1250 талаар материал хүргэсэн, -Үйлчлүүлэгчид уриалга хүргэх үүднээс байцаагчийн өмнө 15 ширхэг шилэн баннер “Авлигагүй бүс” уриа үг хэвлүүлэн байршуулсан Давхардсан тоогоор 25,879 иргэд, даатгуулагчдад хүргэсэн болно. Мөн авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар телевизэд 4 нэвтрүүлэг, сонинд-18 бичвэр, сайтад 5 мэдээлэл оруулж хамтран ажилласан.</p>	
<p>5.7.Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, facebook, болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр</p>	<p>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх</p>	<p>Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, facebook, Нийгмийн даатгалын албан ёсны цахим хуудас бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сурталчилгааны самбар - 32 • Албан ёсны цахим хуудас - 32 • Тв шторк-4 • Теле зохиомж-2 	

<p>түгээх ажлыг зохион байгуулах;</p>		<ul style="list-style-type: none"> • Зурагт хуудас-4 • Албан хаагчдын уриалсан хувийн цахим хаяг-85. <p>Давхардсан тоогоор 165,578 хүнд мэдээлэл хүрсэн болно.</p>	
<p>5.8 Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчдаа сургалт зохион байгуулсан байх;</p>	<p>- Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>-2023.04.13-14-ний өдөр салбарын “Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалтад” “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ХАСУМ” сэдвээр сургалт зохион байгуулж сургалтад 156 албан хаагч хамрагдав.</p> <p>- Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах сургалтад салбарын албан хаагчид хамрагдсан. Үүнд:</p> <p>-Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад “Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Баяртөгс;</p> <p>-“Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалтад” “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ХАСУМ” сэдвээр сургалт зохион байгуулж сургалтад 156 албан хаагчийг хамруулсан;</p> <p>-Төрийн албаны зөвлөлийн вебинар сургалтаар “Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” “Албан тушаалтны 2022 оны ХАСХОМ гаргах тухай” сэдэвт сургалтад салбарын 600 орчим албан хаагч;</p> <p>-Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр ойрын хугацаанд хийх ажлын хүрээнд цахим сургалтын https://surgalt.ndaatgal.mn/ системд “Авлигагүй, ёс зүйтэй хамт олон” хавтас үүсгэж, холбогдох сургалтын материал, видео ба ппт хичээлүүдийг нэгтгэж оруулсан.</p> <p>-Удирдах ажилтны сургалт зөвлөгөөнд “Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Баяртөгс 60 албан хаагчид;</p>	

			<p>- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл сургалтын сургагч багш нарын сургалтад “Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр НДЕГ-ын Тамгын газрын хуулийн мэргэжилтэн Ө.Нармандах 35 албан хаагчид;</p> <p>- Нийгмийн даатгалын шинэчлэн батлагдсан багц хуулийн шинэчлэл бүсийн сургалтын хөтөлбөрт Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг багц хичээлийн агуулгад оруулж, сургалтад оролцсон салбарын нийт 1195 албан хаагчид мэдээлэл хүргэсэн.</p>	
	5.9 НДЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний биелэлтэд мониторинг хийж, зөвлөмж гаргах;	-Мониторинг хийж, зөвлөмж гаргасан байх;	-Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны ажлын төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 5 зорилтын 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тус төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдээгүй байна.	